



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/426

Ховд

「 Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай 」

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн дөрөвдүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад орон нутгийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 2.9 дэх заалт Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын засвар 35,0 сая төгрөг, 2.10 дахь заалт Аймгийн Засаг даргын Тамгын газрын шугам сүлжээ, сантехникийн засвар 45,0 сая төгрөгийн ажлуудын худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулан худалдан авах ажиллагааг 09 дүгээр сарын 15-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлтэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтад хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 10 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/ нарт хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

/Б.Батсүх/, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

